



Орхон аймгийн ЗДТГазар

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2014
ОНЫ 12-Р САРЫН 08-НЫ ӨДӨР
ӨГСӨН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨНИЙ ҮҮРЭГ
ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2014 оны 12-р сарын 22-ны өдөр

**1.Шинэ жилийн арга хэмжээг
архи, согтууруулах ундаа
хэрэглэхгүйгээр тэмдэглэх
талаар нийт байгууллага, аж
ахуйн нэгжүүдэд хандаж
гаргасан уриалгыг олон
нийтэд сурталчлах ажлыг
зохион байгуулах :**

▶ **Биелэлт:** Уриалгыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт төрийн болон хувийн байгууллагуудад хүргүүлсэн. Мөн олон нийтийн цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд хүргэн ажиллаж байна.

2. Шинэ жилийн баярыг тэмдэглэхтэй холбогдуулж пиротехникийн хэрэгслэл худалдах, ашиглах асуудлыг журамлах, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах талаар нийт аж ахуйн нэгж, иргэдэд сурталчлах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах:

- ▶ **Биелэлт :** Шинэ жилийн баярыг тэмдэглэхтэй холбогдуулж пиротехникийн хэрэгслэл худалдах, ашиглах асуудлыг журамлах ажлын хүрээнд холбогдох байгууллагууд хамтран хяналт шалгалтыг тогтмол явуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр анхааруулга сэрэмжүүлэгийг хүргэн ажиллаж байна. Мөн 12 - р сарын 09-ний өдөр Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын захирал, менежер, дотоод хяналтын ажилтнуудад нийтийн хоолны салбарт хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт зохион байгуулсан байна. Сургалтанд 80 хүн хамрагдсан.

з. 2014 онд яамдуутай байгуулсан үр дүнгийн гэрээ дүгнэх, 2015 онд хийх ажлын талаар гэрээний төсөлд тусгах саналаа холбогдох яамдуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах

▶ **Биелэлт : 2014 онд яамдын сайд нартай байгуулсан гэрээг дүгнэх, 2015 онд байгуулах гэрээний төсөлд тусгуулах тодорхой ажил саналыг тусган холбогдох яамдуудад тус тус хүргүүлэх ажлыг зохион байгуулсан болно.**

**4. Авто замын хальтиргаа
гулгааг арилгах, хот доторх
цас цэвэрлэх ажлыг
үргэлжлүүлэн зохион
байгуулах:**

- ▶ **Биелэлт** : Явган зам болон авто замын цас, мөс цэвэрлэх ажлыг 1800га газарт хийгдсэн. Халтиргаа гулгаанаас сэргийлж бодис 400 тн, давс 3600 тн, хайрга 72мз нөөцтэйгөөр ажлыг зохион байгуулан ажиллаж байна

**5. 5-р микрийн 1, 3-р
микрийн 11-р байрны
халаалт доголдож буй
асуудлыг яаралтай судалж
шийдвэрлэн, танилцуулах**

- ▶ **Биелэлт** : 5-1, 3-11-р байранд өргөтгөл барьснаас болж дээд талын айлуудын халаалт доголдох асуудлыг “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-аас өргөтгөл барьсан айл өрх, ААНБ-уудад мэдэгдэл хүргүүлэн халаалтыг хэвийн ажиллагаанд оруулсан байна.

Анхаарал тавьсанд баярлалаа



2014 оны 12-р сарын 22